



НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 02 өдөр

Дугаар A/32

Улаанбаатар хот

Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан
сэргийлэх байнгын ажиллагаатай
зөвлөлийг шинэчлэх тухай

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 29.1.3 а, в, 29.1.6 а, б, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь хэсэг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 189 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/473 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тайлагнах, гамшгийн аюулын бэлэн байдлыг хангахад мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд уялдуулан зохицуулж, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий дүүргийн “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг нэгдүгээр, “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн ажиллах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн дарга Дэд бүтэц, хот төлөвлөлтийн асуудал хариуцсан төслийн удирдагч /Б.Батбаяр/-д даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан Баянзүрх дүүргийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай салбар зөвлөлийг шинэчлэн байгуулж, ажиллах журам батлах тухай” А/433 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Н.БАЯРМӨНХ

Баянзүрх дүүргийн Засаг даргын
2021 оны 04 дугаар сарын 02 -ны
өдрийн 4/32 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БАЙНГЫН
АЖИЛЛАГААТАЙ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Дэд бүтэц, хот төлөвлөлтийн асуудал хариуцсан төслийн удирдагч
Гишүүд:	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн орлогч Баянзүрх дүүргийн Газар зохион байгуулалтын албаны дарга Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга Баянзүрх дүүргийн Боловсролын хэлтсийн дарга Шинжлэх Ухааны Академийн Одон орон, геофизикийн хүрээлэнгийн Газар хөдлөлт судлалын салбарын Эрдэмтэн, нарийн бичгийн дарга /тохиролцсоноор/
Нарийн бичиг:	Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Баянзүрх дүүргийн Засаг даргын
2021 оны 02 дугаар сарын 04 -ны
өдрийн 432 дугаар захирамжийн
2 дугаар хавсралт

ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Дүүргийн Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай салбар зөвлөл /цаашид "Байнгын ажиллагаатай зөвлөл" гэх/ нь Монгол Улсын Үндсэн хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, энэ журмыг удирдлага болгон ажиллана.

1.2. Байнгын ажиллагаатай зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг дүүргийн Засаг дарга баталж, Дэд бүтэц, хот төлөвлөлтийн асуудал хариуцсан төслийн удирдагч Байнгын ажиллагаатай зөвлөлийг удирдана.

1.3. Байнгын ажиллагаатай зөвлөлийн ажлын алба нь дүүргийн Онцгой байдлын хэлтэс байна.

1.4. Байнгын ажиллагаатай зөвлөл нь нийслэлийн Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлд хэрэгжүүлсэн ажлаа тайлагнана.

1.5. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дүүргийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

1.6. Байнгын ажиллагаатай зөвлөл нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хурлаараа хэлэлцэж шийдвэр, зөвлөмж, тэмдэглэл гаргана.

1.7. Байнгын ажиллагаатай зөвлөл нь улирал бүр хуралдаж, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, ажлын явцтай танилцан шийдвэр гаргана.

1.8. Байнгын ажиллагаатай зөвлөл нь ажлын шаардлагын улмаас ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

1.9. Газар хөдлөлтийн гамшгийн нөхцөл байдал үүссэн нөхцөлд утсаар болон биет холбоогоор дуудуулахгүйгээр шууд дүүргийн Засаг даргын Тамгын газрын байранд цуглана.

Хоёр. Байнгынажиллагаатай зөвлөлийн эрх, үүрэг

2.1. Байнгын ажиллагаатай зөвлөл дараах үүрэгтэй байна. Үүнд:

2.1.1. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангуулах ажлыг дүүргийн нутгийн захиргааны байгууллагаар гүйцэтгүүлэх, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангуулах үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах;

2.1.2. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх асуудлаар бусад байгууллагатай хамтран ажиллах, туршлага солилцох;

2.2. Байнгын ажиллагаатай зөвлөл дараах эрхтэй байна. Үүнд:

2.2.1 Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол болон бусад шийдвэр, нийслэлийн Засаг дарга, Байнгын ажиллагаатай зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл сонсох, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;

2.2.2. Газар хөдлөлтийн бүс дэх барилга байгууламжийн зураг төсөл, барилга угсралтын ажил, хүлээн авах, хяналт болон стандарт, норм, дүрмийн шинэчлэлийн талаарх мэдээлэл солилцох, хот төлөвлөлт, аюулгүй байдлын талаарх асуудлыг хэлэлцэж, шийдвэр гаргах;

Гурав. Байнгын ажиллагаатай зөвлөлийн гишүүний эрх, үүрэг

3.1. Байнгын ажиллагаатай зөвлөлийн гишүүн дараах үүрэгтэй байна. Үүнд:

3.1.1. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны талаар хийсэн ажлаа зөвлөл болон дүүргийн Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай салбар зөвлөлд тайлагнах;

3.1.2. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг бууруулах асуудлаар гадаад орон, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, туршлага солилцох;

3.1.3. Байнгын ажиллагаатай зөвлөлийн үйл ажиллагаа, хуралдаанд идэвх санаачилгатай оролцох;

3.1.4. Байнгын ажиллагаатай зөвлөлийн хуралд оролцох боломжгүй болсон тохиолдолд Зөвлөлийн даргад албан бичгээр урьдчилан мэдэгдэх, хэлэлцэж буй асуудлаар саналаа бичгээр ирүүлэх;

3.2. Байнгын ажиллагаатай зөвлөлийн гишүүн дараах эрхтэй байна. Үүнд:

3.2.1. Зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудаас мэдээлэл авах, үүрэг даалгавар өгөх, хяналт тавих;

3.2.2. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах, эрсдэлийг бууруулах асуудлаар Байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн хуралд асуудал танилцуулах, санал гаргах;

3.2.3. Байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гарах;

Дөрөв. Байнгын ажиллагаатай зөвлөлийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг

4.1. Байнгын ажиллагаатай зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах үүрэгтэй байна. Үүнд:

4.1.1. Хуралдааны бэлтгэлийг хангах;

4.1.2. Хуралдааны хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоож, хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг Байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн даргаар батлуулах;

4.1.3. Байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн төлөвлөгөө, шийдвэрийг боловсруулж, батлуулан хэрэгжилтэд хяналт тавих;

4.1.4. Байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн Ажлын алба болон гишүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, уялдаа холбоог хангах;

4.1.5. Байнгын ажиллагаатай салбар зөвлөл үйл ажиллагаа явуулахад шаардагдах зардлын тооцоог гаргаж, зөвлөлийн даргад танилцуулах;

4.1.6. Байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хөтлөх, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр Байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн хуралдаанд танилцуулах, зөвлөлийн баримт бичгийг зохих журмын дагуу эмхлэн хадгалах;

4.2. Байнгын ажиллагаатай зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах эрхтэй байна.Үүнд:

4.2.1. Холбогдох асуудлаар дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудаас мэдээлэл гаргуулан авах;

4.2.2. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг бууруулах чиглэлээр үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр зөвлөлийн гишүүдээс дэмжлэг авах;

4.2.3. Байнгын ажиллагаатай зөвлөлийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах;

Тав. Байнгын ажиллагаатай зөвлөлийн Ажлын албаны эрх, үүрэг

5.1. Байнгын ажиллагаатай зөвлөлийн Ажлын алба дараах үүрэгтэй байна. Үүнд:

5.1.1. Байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн хуралдааны бэлтгэл хангах, үйл ажиллагааны төлөвлөлт, биелэлтийг нэгтгэх, танилцуулах ажлыг зохион байгуулах;

5.1.2. Байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах;

5.2. Байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн Ажлын алба дараах эрхтэй байна. Үүнд:

5.2.1. Байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн ажилд шаардлагатай бичиг баримт, мэдээ, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах;

5.2.2. Үйл ажиллагаагаа зохион байгуулахад тус зөвлөлийн дарга, гишүүдээс шаардлагатай дэмжлэг туслалцаа авах;